

**“ХҮНСНИЙ НОГОО” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(2020 оны жилийн эцсийн байдлаар, явцын тайлан)

2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1.	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоол		Зорилго: Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангахад зорилго оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хугацаа: 2018-2022 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймаг, нийслэлийн ХХААГ, ХААДС, Гадаадын төслүүд		
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		<p>Зорилт 1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах;</p> <p>Зорилт 2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх;</p> <p>Зорилт 3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх;</p> <p>Зорилт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.</p>		
5.	Үзүүлэлт	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Тухайн жилийн төсөв: Улсын төсвөөс 160.0 сая төгрөг; НҮБ-аас хүнсний ногооны үр олгоход 111.2 сая төгрөг Орон нутгийн төсвөөс 2,944.2 сая төгрөг; Гадаадын төслөөс 4,350.5 сая төгрөг; Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 38,869.9 сая төгрөг (Иргэд аж ахуйн нэгжүүдийн Iга-д хүнсний ногоо тариалах, арчлах, хураах зардлыг нийт тариалсан талбайгаар тооцож гаргалаа. Ингэхдээ байцааг 7.4 сая, шар лууван 4.9, шар манжин 4.0 сая, сонгино 5.9 сая төгрөгөөг тус бүрийг тооцсон болно) - Нийт 46.53 тэрбум төгрөг.		
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл	Хувь
		Сая төг	160.0	160.0	100.0
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт		
	Зорилт 1.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 4-7 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 2.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 7-14 дүгээр хуудсыг үзнэ үү.		

	Зорилт 3.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 14-16 дугаар хуудсыг үзнэ үү.
	Зорилт 4.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 16-21 дүгээр хуудсыг үзнэ үү.
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангах зорилготой “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, аймгуудад “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А-127 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.</p> <p>Хөтөлбөр хэрэгжсэнээр 2020 онд хүнсний ногоо тариалдаг 804 аж ахуйн нэгж, 15949 иргэн 9805.0 га-д хүнсний ногоо тариалсан. Эдгээр хүнсний ногоо тариалсан аж ахуйн нэгжийн 41.3 хувь, иргэдийн 56.6 хувь нь шууд хөтөлбөрийн үр шимийг хүртсэнээр нийт 115,074.9 тонн хүнсний ногоо хурааж авсан байна. Энэ нь 2019 оноос тариалалт 1.4 мянган га-аар, 16.4 мянган тн-оор буюу тариалалт 16.5 хувиар, хураан авсан ургацын хэмжээ 16.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд 2020 онд ХХААХҮ-ийн сайдын багц, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын төслөөс нийт 7.66 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.</p> <p>“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 3 дахь жилийн байдлаар 91.2 хувиар дүгнэгдлээ. Өнгөрсөн жилийн үнэлгээнээс 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой үргэлжлүүлэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй.</p> <p>Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж хэд хэдэн зорилтын хүрээнд заасан ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа ХХААХҮЯ-ны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээний санхүүжилт маш бага байна. Тухайн жилийн хэрэгжилтээс дүгнэхэд орон нутаг, хувийн хэвшил, гадаадын төслийн санхүүжилтээр тус төслийн дийлэнх хэсэг хэрэгжиж байгаа нь харагдаж байна.</p> <p>ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-145 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйг дэмжих санд үлдэгдэлтэй байсан тоног төхөөрөмжүүдийг 50 хувиар хөнгөлж борлуулах шийдвэр гаргаснаа</p> <ul style="list-style-type: none"> - Хүнсний ногооны 99 ширхэг тоног төхөөрөмж 316.5 сая төгрөг, - 87 ширхэг трактор, бууц ачигч, ургамал хамгааллын бодис цацах машин, үрлүүр, сийрүүлүүр, лууван, манжин ухагч зэрэг 97 ширхэг хөдөө аж ахуйн машин 2,032.0 сая, - 29 ш усалгааны тоног төхөөрөмж 818.7 сая бороожуулагч <p>Нийт 3,167.2 сая төгрөгийн санхүүжилт гаргасан байна.</p> <p>Үндэсний хөтөлбөрийн үр дүнг аймаг, сумдаар нэгтгэн тайлагнаж, тайланг сайтар боловсруулсан байна.</p> <p>Улсын хэмжээнд 390 удаагийн сургалтаар 46,149 хүн хамрагдсан байна.</p>

		<p>Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд төсөв, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг ХХААХҮЯ, аймгийн ХХААГ-уудын зүгээс өөрсдийн бололцоог дайчлан үр дүнтэй хэрэгжүүлсэн нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний ажлын дүнгээс харагдаж байна.</p> <p>Үндэсний хөтөлбөрийн тайланг яам, харьяа байгууллагууд, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар дамжуулж тайлагнуулж, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.</p> <p>ЗӨВЛӨМЖ:</p> <p>1. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх,</p> <p>2. Хүнсний ногоо шинээр тариалах сонирхолтой аж ахуйн нэгж иргэдийг дэмжих, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлд ХХААХҮЯ-аас анхаарч бодлогоор дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг хүнсний ногоо тариалах сонирхолтой бүлэг хоршоодыг дэмжих, туршлагатай ногоочдыг боловсруулах үйлдвэр байгуулах, хоршиж ажиллах чиглэлд зээлийн дэмжлэгт хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,</p> <p>3. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх, Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх ажлуудыг эрчимжүүлэхийг тус тус зөвлөмж болгож байна,</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, ХААДС, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Зорилт, арга хэмжээний үнэлгээ)	91.2	93.75	87.7	96.0	87.27
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

“ХҮНСНИЙ НОГОО” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<p>1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах;</p>						
1	1.1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;	2018 - 2022			<p>Монгол улсын Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолоор "Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амыг жилийн турш шинэ ургацын нарийн ногоогоор тасралтгүй хангах зорилгоор 20 га талбай бүхий өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах" төслийг хэрэгжүүлэх, шаардагдах 50.0 сая ам.долларын эх үүсвэрийг гадаад улсын болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох яамдад даалгасан. АНУ, БНСУ, Австри улс, БНХАУ-ын холбогдох байгууллагуудад өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах төслийн санал, танилцуулгыг хүргүүлж хамтран ажиллаж зарим үр дүнд хүрээд байна. Тухайлбал “Улаанбаатар хотын иргэдийн хүнс, тэжээлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ухаалаг хүлэмжийн аж ахуй, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төслийг 2021 оноос хэрэгжүүлэхээр Солонгосын хөдөөгийн хөгжлийн эдийн засгийн хүрээлэнтэй хамтран боловсруулж Сангийн ямаар дамжуулан БНСУ-ын Койка ОУБ-ын хөгжлийн албан ёсны санхүүжилтээр хэрэгжүүлэх саналыг хүргүүлсэн ба урьдчилсан байдлаар 7.0 сая ам долларын төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдээд байна. Мөн АНУ-аас хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд зориулан 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх" төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 228 сая төгрөгийн өртгөөр 500 м2 өвлийн хүлэмжийг байгуулж байна. ЖДҮХөгжүүлэх сангаас Говь-алтай, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг Улаанбаатар хотын 19 аж ахуйн нэгжид хүлэмжийн аж ахуйг байгуулахад зориулан 1.886 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.</p>	90%

2	1.2. Орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх;	2018 - 2022			АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх" төслийн хүрээнд 160 иж бүрдэл 9560 м2 талбай бүхий зуны хүлэмжийг тендер шалгаруулан Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/85 дугаар тушаал гаргаж тенерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулав. Нийлүүлсэн хүлэмжийг хүлээн авч төсөл хэрэгжиж буй Сэлэнгэ, Дархан-уул, Төв, Увс аймагт хүргэн өгч суурилуулан тариалалтыг хугацаанд нь хийв. Улсын төсвийн 74.25 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м2 талбай бүхий 45 иж бүрдэл нийт 1440 м2 талбай бүхий нийлэг хальсан хүлэмжийг нийлүүлж 2021 онд өрхийн хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгохоор бэлдээд байна. Булган аймагт Шинэ хөдөө төслөөр 120м2 хүлэмж 101 ширхэгийг 11 суманд олгосноор 12120 м2 талбайд хүлэмжийн аж ахуй эрхлэх боломж бүрдсэн.	100%
3	1.3. Хүлэмжинд мөөг, ашигт таримал, гүзээлзгэнэ тариалахыг дэмжиж, гидропоник болон босоо тавиурт усан орчинд ногоо ургуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх;	2018 - 2022			Улаанбаатар хотын “Грийн сити гардэн” ХХК, “Төгс ургац” ХХК, “Грийн яард” ХХК-иуд хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль, навчит ногоо тариалах технологийн бүрэн нэвтрүүлэв. “Төгс ургац” ХХК гидропоник технологиор 1м ² талбайгаас 50 кг өргөст хэмх хураан авч нэгжийн ургацыг 2 дахин нэмэгдүүлээд байна. Япон улсын Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах төслийн хүрээнд Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн технологи сайжруулах, борлуулалтыг нэмэгдүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлэх чиглээр төслийн санал бэлтгэж Япон улсын төслийн ажилтнуудтай видео хурал хийж салбарын талаар танилцуулга хийсэн ба 2021 оноос "Өргөст хэмх, чинжүүний тариалалтыг нэмэгдүүлэх, ургалтын хугацааг уртасгаж ургацыг нэмэгдүүлэх, зах зээл маркетингийг сайжруулах", "Мөөгний нэр төрөл, технологийг сайжруулах" тус бүр 20.0 мянган ам.доллар туршилтын төсөл хэрэгжүүлэхээр удирдах хорооны хурлаар шийдвэрлэсэн.	100%
4	1.4. Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын	2018 - 2022			2019 онд ХААДС-аас нийлүүлсэн ургамал хамгааллын бодисын тоо хэмжээ болон тэдгээрийн үлдэгдэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас импортлогч аж ахуйн нэгжүүдийн импортлохоор авсан ургамал хамгааллын бодисын тоо хэмжээг тус тус авч судалгаа хийсний үндсэн дээр 2020 онд шаардагдах тариалалтын үеийн хог ургамалтай тэмцэх, уринш боловсруулахад шаардагдах ургамал хамгааллын бодис, үр ариутгалын бодисын хангамж хэрэгцээ, нэр төрөл, тоо хэмжээг тооцоолж, санал, зөвлөмжийг Хөдөө аж ахуйг дэмжих санд 2020 оны 03 сарын 05-ны өдрийн 06/878 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу ХААДС-аас 2020 оны тариалалтад шаардагдах ургамал	100%

	ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх;				хамгааллын бодис нийлүүлэх ажлыг зохион байгуулсан. 2021 оны тариалалтад шаардагдах ургамал хамгааллын бодисын талаар судалгаа хийсэн. ХААДС-аар дамжуулан 2020 оны тариалалтад зориулан 523 аж ахуйн нэгж, иргэнд 322.2 тн ургамал хамгааллын бодисийг үнийн дүнг 50 хувь хөнгөлж олгосноор тариалалт, уринш боловсруулалтын технологит ажлыг хугацаанд нь гүйцэтгэх боломжоор хангасан. 2021 онд ХААДС-аар дамжуулан тариаланчдад нийлүүлэх бодисын нэр төрөл, тоо хэмжээг гаргаж ХААДС-д хүргүүлэхээр бэлтгээд байна.	
5	1.5. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, зохистой дадал, шинэ технологийг нэвтрүүлэх замаар химийн бодисын хэрэглээг бууруулах;	2018 - 2022			2019 онд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон НҮБ-ын ХХААБ-ын Бодлого эрх зүйн орчин төслийн багтай хамтран “Хөдөө аж ахуйн зохистой дадал”, 2020 онд Монгол-Германы Тогтвортой хөдөө аж ахуй төслийн багтай хамтран Завхан аймгийн Улиастай хотод 2020 оны 7 сарын 22-24-ний өдрүүдэд Ховд, Говь-Алтай, Завхан, Увс аймгуудын төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 60 гаруй тариаланчдад зориулан "Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх" сэдэвт сургалт болон Дархан-Уул, Хэнтий аймгуудад төв болон зүүн бүсийн тариаланчдад зориулан хөдөө аж ахуйн зохистой дадал сургалт, дадлагажигч багш нарыг бэлтгэх сургалтыг тус тус зохион байгуулсан. Сургалтаар хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйд зохистой дадлыг нэвтрүүлэх, ургамал хамгааллын бодис, бордооны зохистой хэрэглээ, ургамал хамгааллын цогц аргын талаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд илтгэл тавьж оролцсон ба мөн оролцогсодод зориулан газар тариалангийн үйлдвэрлэлд мөрдөж буй бодлогын баримт бичиг болон журмуудын эмхэтгэл, сургалтын гарын авлага зэргийг хэвлүүлж тараасан.	90%
6	1.6. Хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт,	2018 - 2022			Тухайн бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримал ургамлын шинэ сортыг сорих, шалгаруулах зорилгоор тариалангийн төвийн бүсэд төмсний 6 сорт сорих ажлыг Ургамал, газар тариалангийн хүрээлэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Гэрээт ажлын хүрээнд тариалангийн төвийн бүсийн 2 байршилд төмсний 6 шинэ сортыг үйлдвэрлэлийн нөхцөлд сорьсоны зэрэгцээ, сорт сорилтын талбайд эрдэмтэн, судлаач, тариаланчдын төлөөлөлийг оролцуулсан үзүүлэх сургалт зохион байгуулав.	100%

	тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь боловсруулж тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж болгон хэрэгжүүлэх;					
7	1.7. Хүнсний ногоог хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022			Хүнсний ногоог байгалийн аргаар болон албадан аргаар хатаах технологийн сургалтыг ХХААХҮЯ, Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоотой хамтран "хүнсний ногоо" төсөл хэрэгжүүлж байгаа Төв аймгийн борнуур, Дархан-Уул аймгийн Орхон суманд зохион байгуулахад технологийн зөвлөмж боловсруулж оролцсон. Тус төслийн шугамаар ногоо хатаах бага оврын төхөөрөмжийг ногоочдод төслөөс олгосон.	100%
8	1.8. Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх.	2018 - 2022			Хүнсний ногооны 10 нэр төрлийн таримлаар яамны дотоод мэдээллийг аймгуудаас авч нэгтгэж мэдээллийн сан үүсгэсэн. Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-той хамтран газар тариалангийн маягтыг шинэчлэх ажлын хүрээнд ургамлын генетик нөөцийн мэдээний маягтад хүнсний ногооны талаарх мэдээллийг авч байхаар оруулсан. Цаашдаа ҮСХ-той Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногооны /таримлын нэр төрлөөр/ талаарх мэдээллийн тоо хэмжээ, чанарыг нэмэгдүүлэн, мэдээллийн санг сайжруулах талаар хамтран ажиллахаар тохиролцсон болно.	70%

2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх;						
9	2.1. Хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага, дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах;	2018 - 2022			Хөдөө аж ахуйг дэмжих санд үлдэгдэлтэй байсан хүнсний ногоонд зориулагдсан бага оврын ухагч, үрлүүр, сийрүүлүүр, мотоблок, трактор зэрэг 300 гаруй техник тоног төхөөрөмжийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-145 дугаар тушаалаар үнийг 50 хүртэл хувиар бууруулж ногоочдод хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон. Архангай аймгийн ногоочид зүтгэх хүч болох трактор 4 ширхэг, анжис 3, хадуур 2, тармуур 2, хаман боогч 2, чиргүүл 2, Хэнтий аймаг дунд оврын трактор 1, дамарч бороожуулагч, дунд оврын трактор иж бүрдэл, мөн мотоблок 1 ш, Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах төслийн хүрээнд Дархан-уул, Сэлэнгэ, Увс, Төв аймгийн ногоочид хоршоонд 50 морины хүчин чадалтай трактор -4 ширхэг, анжис 4, үрлэгч-4, хураагч-4, роторт сийрүүлэгч 4, Бүгд найрамдах Солонгос улсад үйлдвэрлэсэн мотоблок 4 агрегатын хамт 5 иж бүрдлийг 20 ширхэгийг 39 бүлгийн 1048 өрхөд дэмжлэгээр олгосон.	100%
10	2.2. Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;	2018 - 2022			Сав баглаа, боодлыг сайжруулах, загвар бий болгох зорилгоор Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслөөр 39 бүлгийн 1048 өрхийн ногоочдын төрөл бүрийн ногоог хэрэглэгчдэд стандартын дагуу борлуулах зорилгоор "Сав баглаа боодол, маркетинг" худалдан авалтаар 1 кг- 3 кг-аар савлах сеткэн тор 200.0 мянган ширхэг, 4-55 кг аар савлах 300.0 мянган ширхэг, даавуун тор 3000 ширхэг, уутан дээр наах стикер лого 500.0 мянган ширхэг, цаасан уут 150000 ширхэг н уутыг хаяг шошготойгоор зах зээлд борлуулахад ашиглаж туршсан. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг түүвэр аргаар судлахад 99 хувь дэмжсэн байна. Тус төслийн хүрээнд нийслэл хотод 6 цэгт борлуулалтын төвийн ТҮЦ-ийг байгуулав. ТҮЦ-д тавих 16 ширхэг модон лангуу бэлтгэсэн. Хүнсний ногооны бага оврын гар үрлэгчийг ХХААХҮ-н сайдын А-145 дугаар тушаалаар үнийг 50 хувь хөнгөлж 1 ширхэг нь 150.0 мянган төгрөгийн үнэтэйгээр 100 ногоочинд олгов. Архангай аймаг хүлэмжинд хэрэглэдэг гар багаж 10, хүрз 10, төмс ухагч 1, сийрүүлэгч 3 ширхэг, Төв аймаг 4 сумын ногоочдын бүлгүүдэд ногооны үр, багаж, Говь-алтай аймаг 15 сумын 40 иргэнд гар багажны иж бүрдэл, Увс “Хүлэмж дэд хөтөлбөр”-ийн хүрээнд мотоблок болон сольж угсардаг үрлэгчийг – 2 ширхэгийг, Баян-өлгий аймаг 165 өрхөд хүрз, тармуур, гапуу гар багаж нийт 495 ш тусламж үзүүлсэн.	100%

11	2.3. Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022		<p>Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах төслийн хүрээнд “Хоршооны дундын хөрөнгө оруулалтын сангийн журам”-ыг боловсруулж төслийн хөрөнгө оруулалттайгаар Увс аймгийн Улаангом сум “Чандмань торгон үр” хоршоо, “Үрийн өгөөжит гол” хоршоо, “Комплекс хүлэмжит байц”, Сэлэнгэ аймгийн Ерөө сум “Ерөө Ургац” хоршоо, “Бороогийн шим” хоршоо, Дархан-уул аймгийн Орхон сум “Орхон шимт ногоон хөрс” хоршоо болон “Газар шим өгөөж” хоршоо, Төв аймгийн Борнуур сумын ногоочдын 39 бүлгийн 1048 өрх хоршоо болон нэгдсэн зохион байгуулалтад орж улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн. Хоршооны бүлэг тус бүр бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтанд хамрагдсан. Хоршоо тус бүр үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөгөө боловсруулахдаа агуулгын хувьд нэгдсэн нэг хөтөлбөрийн дагуу боловсруулсан. Үүнд: Хоршооны танилцуулга, хоршооны өрхийн мэдээлэл, хоршооны нийт хөрөнгө, үйлдвэрлэл, үйлчилгээний мэдээлэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, удирдлага зохион байгуулалт, зах зээлийн судалгаа, хүнсний ногооны үйлдвэрлэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны эдийн засгийн тооцоолол зэргийг тусгасан. Монгол ногоо төслөөр борлуулалтын “Цэвэр хөрсний шим дундын хоршоо” байгуулсан. Дээрх бүтэц тогтвортой ажилласанаар ногоочид тогтвортой ургац хураахад анхаарч харин борлуулалтаа өөрсдийн төлөөлөл бүхий хоршоогоороо дамжуулан хийх жишиг шинээр үүсэн бий болж байна. Зах зээлд борлуулалт хийх зорилгоор нэгдсэн зохион байгуулалтанд орсон нийт 4 аймгийн 7 сумын ногоочдын байгуулсан “Цэвэр хөрсний шим” дундын хоршоонд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Тус дундын хоршоо нь 2020 оны 12-р сарын байдлаар гишүүдээсээ 1,130 тонн хүнсний ногоо худалдан авч 1.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Тариаланчид “Цэвэр хөрсний шим” дундын хоршоотой бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ногоогоо зах зээлд шууд нийлүүлж байна. Үүний тулд ногоочид гэрээний дагуу бүтээгдэхүүнээ тээвэрлэн хүргэж ирдэг.</p>	100%
12	2.4. Хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн	2018 - 2022		<p>Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах нь төсөлд 39 бүлгийн 306 өрх байгаа ба үүнээс 37,9% нь өрх толгойлсон болон зорилтот бүлгийн өрхүүд хамрагдсан байна. Мөн төсөлд хамрагдах нийт 39 бүлгийн 1048 өрхийн гишүүдийн 53.5% буюу 561 гишүүн нь эмэгтэйчүүд, 55 өрх толгойлсон, эмзэг бүлгийн өрх байна. Нийт ногоочдын бүлгийн ахлагчдын хувьд, 30.7% буюу 12 эрэгтэй ахлагчтай байна. Ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үр 4 сумын ногоочдын бүлгүүдэд шар луувангийн үр, шар манжингийн үр, хүрэн манжингийн, бөөрөнхий сонгины үр,</p>	90%

	дэмжлэг олгож, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;				урт сонгины үр, бөөрөнхий сонгины төл үр зэрэг нийт 757 кг үрийг түгээсэн. Ногоочдын бүлгүүд төслөөс санхүүжсэн үрээр нийт 234.8 га-д хүнсний ногооны тариалалт хийж, 2553.7 тн ургац хураан авсан. Говь-алтай аймаг 5 сумын залуу 8 иргэнд 40 сая төгрөгийн зээл, баянхонгор аймаг шинээр өрхийн тариалан эрхэлж буй иргэнд өргөст хэмх 600, улаан лооль 200, байцаа 300, амтат чинжүүний 200 нийт 1300 ширхэг үрсэлгээг бэлтгэн хөнгөлөлттэй үнээр ийлүүлж тариалалтын зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан. Мөн залуу 2 гэр бүлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 900,000 төгрөг, хүнсний нарийн ногооны үрийн дэмжлэг үзүүлж 1,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн. Хэнтий аймаг бага орлоготой залуу гэр бүлийг дэмжин төл сонгины үр 200 кг, лууван 10 кг, манжин 5 кг, хүрэн манжин 5 кг, нийт 220 кг үрийг Хэрлэн сумын 25 өрхөд хуваарилан өгснөөр 35 тн ургац хураан авсан байна. Төв аймаг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Бүлгээр хүнсний ногоо тариалах” төслөөр 7 сумын 13 бүлгийн 62 залуу өрхөд 31 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
13	2.5. Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилттэй технологи нэвтрүүлэх;	2018 - 2022		БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн төмс, хүнсний ногооны бага болон дунд оврын усалгааны тоног төхөөрөмж, өргөн авцын бороожуулагчийг тус тус 50 хувь хөнгөлж, жилийн 6 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай нөхцөлөөр усалгааны тоног төхөөрөмжийг олгосон. Үүний үр дүнд хүнсний ногооны 359 га талбайг услах боломж бүрдсэн. "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба Усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 12 услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах ажлын зураг төсөл байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийж зураг төсөл боловсруулсан байна. Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн хүнсний ногооны үр үржүүлэг, сорт сорилтын талбайн услалтын системийн инженерийн тооцоолол, зургийг хийж 2020 оны 7 сард 5 га талбайд Израйл улсын бичил бороожуулагч төхөөрөмжийг суурилуулав. Говь-алтай аймгийн Шарга сумын услалтын системийн толгойн барилгыг “Газар шим “ ХХК 100 сая төгрөгөөр засварлан ашиглалтад хүлээлгэн өгсөн. Баянхонгор Бумбат, Герман толгой зэрэг газруудыг нэгдсэн цахилгаан эрчим хүчинд холбосноор 48 га талбайг усаагаажуулж, ногоо тарьдаг 56 өрхийн усалгаа, 200 өрхийн 2 гүн өрмийн худгийг шинээр гаргасан. Хэнтий аймгийн Хэрлэн суманд Монгол төмс төслийн хүрээнд хүнсний ногоо тариалж буй 10 иргэнд дуслын усалгааны систем, дамарт бороожуулагч ногоочдын бүлэгт өгсөнөөр 10 га талбайг усалгаажуулсан байна. Увс аймгийн Үр үржүүлэгч бүлгийн 100 өрхөд 5 худаг, 2,5 км зам бүхий эрчим хүчний эх үүсвэрийн шугам ашиглалтад оруулан хүлээлгэж өгсөн. Үүний үр дүнд ус хуримтлуулан таримлын усалгааг	90%	

					технологийн хугацаанд хийх боломж бүрдлээ.Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ц.Цогбадрах, Дархан-Уул аймгийн Б.Хадбаатар, Улаанбаатар хотын СХД-ийн “Их булгийн тохой” ХХК, Төв аймгийн Борнуур сумын “Централ ланд продьюссер” ХХК, Төв аймгийн Борнуур сумын Э.Баярмаа, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн иргэн Ч.Алтанцэцэг, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Д.Өлзийжаргал нар авсан байна.	
14	2.6. Гэрийн болон үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний ногооны стандартыг боловсруулж мөрдүүлэх;	2018 - 2022			Хүнсний ногооны зоорь байгуулахад баримтлах барилгын норм ба дүрэм, хүнсний ногоо хүлээн авах, хадгалах, тээвэрлэх зэрэг холбогдох стандартуудын нэгдсэн эмхэтгэлийг нэгтгэн боловсруулж 700 хувь хэвлүүлэн орон нутагт хүргэхэд бэлэн болгов. Эс Эф Си Эс ХХК болон НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй Хууль эрх зүйн 4-р бүрэлдэхүүн хэсэгтэй хамтран Хөдөө аж ахуйн зохистой дадлын стандартыг хүнсний ногооны тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ХААЗД-ын баталгаажуулалтын үндэсний тогтолцоо бий болгох, ХААЗД-ын баталгаажуулалт хийлгэхэд хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд: 1) ХААЗД-ын зөвлөхийг бэлтгэх сургалт 2 удаа зохион байгуулав. ХААЗД-ын аудиторын сургалт 1 удаа зохион байгуулав. Бөөрөнхий байцаа, үндэс үртэн ногоо, сонгино, саримс, хэмх, лооль зэрэг таримал тус бүрээр ХААЗД-д суурилсан технологийн зөвлөмж бэлтгэн, хэвлүүлэх, Газар тариалангийн үйлдвэрлэлд ХААЗД-ын шаардлагыг хангаж байгаад үнэлгээ хийх өөрийн үнэлгээний хуудсыг 3 шатлалтайгаар боловсруулав. Үүнд: Тариалалтаас эхлэн борлуулалт хийх аж ахуйн нэгжид зориулсан, Тариалалтаас эхлэн ургац хураалт, хадгалалт хийх аж ахуйн нэгжид зориулсан, Тариалалтаас эхлэн тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжид зориулсан.Зөв зохистой хоололт, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх сэдвээр нийт 51 минутын 10 цуврал видео контентийг Оюундарь хоолны зөвлөх болон “Монголын органик ногоон хүнсний холбоо” ТББ-той хамтран хийж, Youtube болон Facebook хуудсаар нийтэд танилцуулав. Хүний эрүүл мэндийн байдалд хооллолтын үзүүлэх чухал нөлөө, зохистой хооллолтын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй зөв, шинэлэг мэдлэг, мэдээллийг иргэдэд хүргэж, нийгмийн эрүүл мэндийг дэмжихэд хувь нэмэр оруулахын зорилгоор энэхүү цуврал хичээлүүдийг бэлтгэн хүргэсэн. “Олон наст сонгинолог ургамал тариалах” гарын авлага боловсруулан гаргав. Энэхүү гарын авлагад олон наст таримал болон тарималжуулсан сонгинолог ургамал тариалах арга ажиллагааг тусгав.	90%
15	2.7. Услалтын системийн	2018 - 2022			БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд төмс, хүнсний	90%

	барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;				ногооны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнд 350 га-ийн усалгааны тоног төхөөрөмжийг 6 жилийн хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй 50 хувийн хөнөглөлттэй нөхцөлөөр олгоод байна. Увс аймгийн Баруунтуруун сумын “Хөдөлмөрийн тун” хоршоо, Төв аймгийн Борнуур сумын “Зэлийн гол” ХХК, Дархан-Уул аймгийн Дархан сумын “Дархан бейг трейд” ХХК-д 307.2 сая төгрөгийн үнэ бүхий 25 га талбайг услах хүчин чадал бүхий дунд оврын дамартай бороожуулагч 10 ширхэг, “Дархан Уул аймгийн “Шинэ-Орчин трейд” ХХК, Улаанбаатар хотын СХД-ийн Их булгийн тохой ХХК-иуд 54 га талбайг услах хүчин чадал бүхий 200 сая төгрөгийн үнэ бүхий том оврын 2 ширхэг шугаман бороожуулагчийг тус тус зээлээр авсан.	
16	2.8. Инженерийн хийцтэй томоохон усалтын систем бүхий иргэн, аж ахуйн нэгж таримлын сэлгээндээ хүнсний ногоо тариалах санаачилгыг дэмжих замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх;	2018 - 2022			БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнд 350 га-ийн усалгааны тоног төхөөрөмжийг 6 жилийн хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй 50 хувийн хөнөглөлттэй нөхцөлөөр олгоод байна. АХБ-ны 40.0 сая ам долларын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймгуудад 7.7 мянган га талбайг услах хүчин чадал бүхий 12 усалтын системийг шинээр барьж, сэргээн засварлахад 29.2 сая ам доллар зарцуулагдах бөгөөд усалтын системийн барилга угсралтын ажил 2021 оноос эхлэж 2025 онд ойн зурвас байгуулан, усалгааны тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн дуусаж 2026 оноос төслийн хүчин чадлаар нь ашиглах юм. Мөн Дархан хот дах Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Увс аймгийн Улаангом хотын Газар тариалангийн хүрээлэн, Дорнод аймгийн Чойбалсан хот дах Газар тариалангийн сургалт Эрдэм Шинжилгээний хүрээлэн, Даланзадгад хот дах газар тариалангийн эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэн хүнсний ногооны үр үржүүлэг, туршилт, сургалт, судалгаа шинжилгээний тоног төхөөрөмжөөр тоноглож нийт 250 га талбайг услах хүчин чадал бүхий усалтын системийг сэргээн засварлах юм.	70%
17	2.9. Байгальд ээлтэй, эрчим хүчний	2018 - 2022			АХБ-ны 40.0 сая ам долларын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймгуудад 7.7 мянган га талбайг услах	90%

	хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг нэмэгдүүлэх;			хүчин чадал бүхий 12 услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлахад 29.2 сая ам доллар зарцуулагдах бөгөөд услалтын системийн барилга угсралтын ажил 2021 оноос эхлэж 2025 онд ойн зурвас байгуулан, усалгааны тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн дуусаж 2026 оноос төслийн хүчин чадлаар нь ашиглах юм. Мөн Дархан хот дах Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Увс аймгийн Улаангом хотын Газар тариалангийн хүрээлэн, Дорнод аймгийн Чойбалсан хот дах Газар тариалангийн сургалт Эрдэм Шинжилгээний хүрээлэн, Даланзадгад хот дах газар тариалангийн эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэн хүнсний ногооны үр үржүүлэг, туршилт, сургалт, судалгаа шинжилгээний тоног төхөөрөмжөөр тоноглож нийт 250 га талбайг услах хүчин чадал бүхий услалтын системийг сэргээн засварлах юм. 2020 онд төмс, хүнсний ногооны агуулахыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1000 тонн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4950 тонн төмс, хүнсний ногооны агуулах шинээр байгуулж, ашиглалтанд оруулсан байна.	
18	2.10. Таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах;	2018 - 2022		2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант суманд 1000 тонн багтаамж, аж ахуйн нэгж өөрсдийн хөрөнгөөр Төв аймгийн Жаргалант суманд 950 тн, Улаанбаатар хотын СХД-т Мөнх агро ХХК 1500 тн, Диши хоршоо 2500 тн, Баянхонгор аймаг 150 тн, Хэнтий аймаг 250 тн, багтаамжтай зоорь барьж ашиглалтад оруулсан. Мөн Монгол Улс - БНПУ-ын Засгийн газар хооронд Монгол Улсад “Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” 10.2 сая еврогийн санхүүжилттэй төслийг 2 багц буюу А. Багц 1. Төмс, хүнсний ногооны агуулах байгуулах. Төсөв нь 7.0 сая еврогоор 5 аймаг, нийслэлд Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий 8500 тонн багтаамж агуулах байгуулахаар төлөвлөж байна. Б.Багц 2. Хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан трактор,техник тоног төхөөрөмж нийлүүлэх. Төсөв нь 3.2 сая еврогоор хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Зоорь барих мөнгөн дэмжлэгээр Төв аймаг орон нутгийн төсвөөс 13.3 сая төгрөг, аймаг хөгжүүлэх сангаас 1 иргэнд 80 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас хүнсний ногооны тариалалт, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 8 сумын 24 иргэнд 156.4 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн.	90%
19	2.11. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ	2018 - 2022		Ногоочдыг борлуулалтаар дэмжих хадгалалт, борлуулалтын нэгдсэн төвийг байгуулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөж тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн ба үр дүнд нь бөөний төвийн Техник эдийн засгийн үнэлгээ батлагдан гарч бүтээн байгуулалтыг хийх 10 га газрын зөвшөөрөл СХД-н 20	70%

	чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;				дугаар хороонд гарсан. Монгол ногоо төслөөс тус санаачлагын хүрээнд өнгөрсөн хугацаанд дараах чиглэлд дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд: Гарах, Шинфади, Саппоро зэрэг Азийн хөгжингүй улс орнуудын бөөний худалдааны төвтэй танилцах туршлага судлах аялал зохион байгуулж оролцогч талуудын мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн. - Бөөний худалдааны төвийн ТЭЗҮ-г боловсруулсан компанийн мэргэжилтнүүдийг сургах чиглэлд дэмжлэг үзүүлсэн. - Өмнөд Солонгос улсын Гарах захын үйл ажиллагаа хариуцсан захирлыг Монгол улсад урьж нийслэлийн удирдлагуудтай уулзуулах, ТЭЗҮ боловсруулсан багт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгүүлсэн. - Монгол- БНСУ-ын хооронд үйл ажиллагаа болон арга зүй, туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Монгол Улсын засгийн газраас баталсан бусад дэд хөтөлбөр, тогтоолуудын хүрээнд төр, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзаж санал солилцсоноор “Бөөний дамжуулан борлуулах төв”-ийг туршилтаар бүсчлэн хөгжүүлэх боломжтой гэсэн санаачилга гарсан. ХХААХҮЯ, Нийслэлийн ЗДТГ, Баясах трейд ХХК хамтарсан гэрээ байгуулахаар хүлээгдэж байна.Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах төслөөр нийслэлд хүн ам төвлөрсөн 6 цэгт борлуулалтын төв барьж ашиглалтад оруулсан. Баянхонгор аймаг орон нутгийн сангийн 36,4 сая төгрөгөөр төмс хүнсний ногооны борлуулалтын цэг барьж ашиглалтад оруулсан.Монгол ногоо төслийн хүрээнд Номин, Оргил супермаркет, Боса, Багануур хүнсний сүлжээ захуудад ногоо нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.	
20	2.12. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;	2018 - 2022		2020 онд Стандарт, хэмжилт зүйн зөвлөлийн хурлаар 1981 оноос хойш шинэчлэгдээгүй байсан “Төмс, хүнсний ногоо хадгалах” MNS 3024:2000 стандартыг шинэчлэн батлууллаа. 2020 онд 9 таримлын стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж, техникийн хороогоор хэлэлцэн батлах шатандаа явж байна. Хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг GAP нэвтрүүлэх, баталгаажуулах 2020 онд Эс Эф Си Эс ХХК болон НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй Хууль эрх зүйн 4-р бүрэлдэхүүн хэсэгтэй хамтран Хөдөө аж ахуйн зохистой дадлын стандартыг хүнсний ногооны тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ХААЗД-ын баталгаажуулалтын үндэсний тогтолцоо бий болгох, ХААЗД-ын баталгаажуулалт хийлгэхэд хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд:1) ХААЗД-ын зөвлөхийг бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулав. 2) ХААЗД-ын аудиторын сургалт зохион байгуулав 3) Бөөрөнхий байцаа, үндэс үртэн ногоо, сонгино, саримс, хэмх, лооль зэрэг таримал	90%	

					тус бүрээр ХААЗД-д суурилсан технологийн зөвлөмж бэлтгэн, хэвлүүлэн ногоочдод гарын авлага өгөв.	
21	2.13. Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах.	2018 - 2022			Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 138 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 06 дугаар сарын 26-наас 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Баянгол дүүргүүдэд байрладаг төмс, хүнсний ногооны дэвшилтэд технологи бүхий зоорь, агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн ургац хүлээн авах бэлтгэл ажлын байдалтай танилцлаа. Агуулах, зоорийн аж ахуй нь ногоочид жимсчидээс нэгдсэн журмаар шууд худалдан авалт хийх гэрээ байгуулсан байдал, ногоочдын борлуулалтыг дэмжих арга хэмжээнд бэлтгэсэн эсэх, тухайн зоорь, агуулах нь эрүүл ахуйн нөхцөл хангаж байгаа эсэх, хадгалалтанд авсан бүтээгдэхүүнийг түгээх аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсан байдалд үзлэг хийн танилцаж, цаашид төрөөс төмс, хүнсний ногооны борлуулалт, хадгалалтыг нэмэгдүүлэх тухай бодлого чиглэлийг танилцуулан, зөвлөмж, зөвөлгөө өгч ажилаллаа.	70%
3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх;						
22	3.1. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг үрийн аж ахуйн тогтолцооны дагуу нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтад оруулж, гарал үүсэл нь тодорхой, чанарын баталгаатай торгон, сортын болон эрлийз үр үйлдвэрлэж, борлуулах	2020 - 2021			Хүнсний ногооны үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй иргэд Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо ТББ-тай гэрээ байгуулан “Ил талбайн ногооны үр худалдан авах” ажлын хүрээнд нутагшсан сортын Увсад үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан шар лууван, шар манжин, хүрэн манжингийн нийт 114.0 сая төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн нийт 3,530 кг үр нийлүүлсэн. Дотоодын үр үйлдвэрлэгч ногоочдод үрийн дэмжлэг болов. НҮБ-аас Хүнсний болон хоол тэжээлийн аюулгүй байдалд COVID-19-ийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хэрэгжих техник туслалцааны хүрээнд төгрөгийн нийт 2,130 кг хүнсний ногооны үрээр төвийн тариалангийн бүсийн 1,430 тариаланчдыг хангах ажлын хүрээнд нутагшсан сортын, чанар стандартын шаардлага хангасан үр нийлүүлсэн. Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбооны АДРА ОУБ-ын “Органик ХАА-н түншлэл” төсөл, НҮБ-ын ХХААБ-ын “Secim Нэмүү өртгийн сүлжээ” төсөл зэрэг ХАА, хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа бусад төсөл, хөтөлбөрүүд мөн холбооны гишүүд болон төсөл хэрэгжиж буй сумдын ногоочдод нийт 836 сая төгрөгийн үнэ бүхий 17 зүйл таримлын 13.3 тонн үрийг 17 аймаг дахь салбар холбоо, 4 үрийн жижиглэн борлуулагч болон орон нутгийн хөдөө аж ахуйн газраар дамжуулан түгээлээ. Энэ нь 2019 оныхтой харьцуулахад үрийн борлуулалт 1.5 дахин	100%

	нөхцөлийг бүрдүүлэх;				нэмэгдсэн байна. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлээр шар лууван, шар манжин, хүрэн манжингийн үрээр хэрэгцээг 100 хувь хангав.	
23	3.2. Агроэкологийн нөхцөлийг харгалзан ногооны үр үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх, үр үржүүлэгчийн мэргэшлийн түвшин, дадлага туршлага, материаллаг баазын хангамж зэрэгт тулгуурлан үр үржүүлэхийг дэмжих;	2020 - 2021			Монгол ногоо төслийн хүрээнд байцааны гибрид үрээр 230 га, хүлэмжийн өргөст хэмх 8.7 га, ил талбайн өргөст хэмх 42.6 га болон хүлэмжний улаан лооль 188,814 м2 -н үрийг бүх аймаг болон тариалан түлхүү эрхэлдэг сумдын тариаланчдаас гибрид үрийн захиалгыг нэгтгэн авч, Герман, Голландын үрийн компаниудтай дистрибюторын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Ингэснээр ногоочдод туршигдаж баталгаажсан сортуудын, сайн чанарын үрийг бөөний үнээр нийлүүлж, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрхийн болон жижиг үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллаа. УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 35 дугаар “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолд “... төмс, хүнсний ногооны үрийн гаалийн албан татварын хувь, хэмжээг “0” -д заасны дагуу 8-р сарын 1-ээс хэрэгжихээр тусгасан нь дотооддоо үйлдвэрлэдэггүй, өндөр үнэтэй эрлийз үр, төл сонгино, үрийн саримс зэргийн үнэ өртөг буурах, худалдан авах боломж муутай тариаланчдад ийнхүү туршигдаж, батлагдсан, сайн чанарын шинэ эрлийз сортын үр хөнгөлөлттэй үнээр хүрч байгаа нь эрлийз сортын үрийн давуу талыг мэдрэх, шинэ технологийг нэвтрүүлэх, хэрэглээг таниулах ач холбогдолтой боллоо. Шинээр ирээдүйтэй сортоор батлагдсан үндэс үртэн болон байцааны шинэ сортын үрийг Увс аймагт, тарвас, амтат гуа, улаан лоолийн үр үржүүлэг Ховд, Дорноговь, Баянхонгор аймгуудад тус тус явагдаж байна. Бага тархацтай, зарим шинэ ирээдүйтэй сортуудын үрийг мөн УГТХ-ийн Дархан-Уул аймгийн Орхон суман дахь үр үйлдвэрлэлийн талбар болон Увс аймаг дахь салбарыг түшиглэн хийгдэж байна. Мөн үр үржүүлгийн ажлыг дэмжиж 2020 онд ВНИИССОК-оос нийт 7 зүйл таримлын 11 сортын супер-элит үрийг үр үржүүлгийн зорилгоор нийлүүлээд байна.	90%
24	3.3. Ногооны үр үйлдвэрлэл эрхлэгчдэд үрсэлгээ бойжуулах зориулалтын хүлэмжийн аж ахуйг байгуулахад	2019 - 2021			Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй Монгол ногоо төслийн хүрээнд Сонгино-Хайрхан дүүргийн 24 дүгээр хорооны “Жишиг гудамж”-ны бүлгийн өрхүүд стандартын шаардлага хангасан, чанартай үрсэлгээний төвдөө 6 төрлийн ногооны 2,000 ширхэг үрсэлгээ ургуулж 2 сая төгрөг, Хэнтий аймгийн Мөрөн сумын ногоочин Ж.Балдандорж 2,500 үрсэлгээ ургуулж 2,5 сая төгрөг, Улаанбаатар хотын Налайх дүүргийн ногоочин Пэлжиржав 3 төрлийн 4,000 ширхэг үрсэлгээ ургуулж 4 сая төгрөг, Хөвсөгөл аймгийн иргэн Дэжид 3000 ширхэг үрсэлгээнээс 2.2 сая төгрөгийн орлоготой болсон.	90%

	нь дэмжлэг үзүүлэх;					
25	3.4. Хүнсний ногооны үрийн тариалан эрхлэгчдэд сэлгээний талбай нэмж олгох ажлыг зохион байгуулах;	2018 - 2022			Улсын хэмжээнд 9.7 мянган га-д хүнсний ногоо тариалсан нь 2019 оныхоос 1400 га талбайгаар нэмж тариалсан. Газар шинээр эзэмшүүлж олгосон аймгуудыг дурьдвал Архангай, Баян-өлгий, Баянхонгор, Говь-алтай, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Хөвсгөл, Улаанбаатар, Говьсүмбэр, Орхон аймгууд олгосон байна. Ногоо тариалах дэд бүтэц бүхий газрыг Увс аймгийн Улаангом сумын инженерийн хийцтэй 12 га-гийн хүчин чадалтай услалтын системийг бүрэн ашиглах зорилгоор 20 өрхөд нийт 5.0 га тариалангийн газрыг шинээр эзэмшүүлсэн, Хэнтий аймгийн хүнсний ногооний үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэнд 15 га газрыг журмын дагуу олгосон байна.	100%
26	3.5. Ногооны шинэ сорт бүтээх, шинэ таримал турших, тэдгээрийн элит сортын баталгаат үр үржүүлгийг дэмжиж, шинжлэх ухаан, технологийн төслийг захиалан эрдэм шинжилгээний байгууллагуудаар гүйцэтгүүлэх.	2018 - 2022			2020 онд Улсын сорт сорилтын зөвлөлийн хурлаар хүнсний ногооны амтат чинжүүний эртийн болцтой “Медаль”, брокколийн эртийн болцтой “Тонус”, сортуудын нутагшсан сортоор батлав. Ирээдүйтэй сортоор бөөрөнхий сонгины эртийн болцтой “Ричихун” F1, хүлэмжийн лоолийн “Hellfrucht”, амтат чинжүү “Мордо”, жижиг жимстэй лоолийн “seminis-sv7160tc - F1”, “TV candy-F1” сортуудыг батлав. Ургамал газар тариалангийн хүрээлэн, Монгол ногоо төсөл, Хөдөө аж ахуйн их сургуулиудад тус тус туршигдаж буй 14 нэр төрлийн хүнсний ногооны 36 сортыг улсын сорт сорилтод туршихыг УССЗ-н хурлаар батлав. “Газар тариалангийн салбарын шинжлэх ухааны байгууллагын ололт амжилтыг ногооны аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга зам, үр сортын туршилт, боломж” сэдэвт талбайн өдөрлөгийг 2020 оны 07-р сарын 24-ний өдөр УГТХ-ийн ногооны үр, сортын туршилт судалгааны талбайд зохион байгуулсан. Талбайн өдөрлөгт Борнуур, Орхон, Ерөө сумдын 30 ногоочдын бүлгийн төлөөлөл 40 ногоочин хамрагдсан. Сургалтыг төслийн олон улсын зөвлөх агрономч доктор Ш.Алтанбадралт, УГТХ-ийн Хүнсний ногоо судлалын секторын эрхлэгч доктор Ц.Нарандэлгэр, ЭША доктор Ж.Байгалмаа, УГТХ-ийн ургамлын генетик нөөцийн секторын доктор Т.Атарсайхан нар удирдав. Монгол ногоо төслийн хүрээнд хүнсний ногооны 19 зүйлийн 47 сортын үрийг оруулж ирэн сорилтонд оруулав. Буурцагтан ургамлын сортын тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 3 сумдын ногоочдод бөөрөн шош, шар, ногоон буурцгийн үр нийлүүлж, экологийн сорилт болон үр үржүүлгийн ажлыг хийлээ. Буурцагт ургамлын үр үржүүлгийн хүрээнд вандуйн 90 кг, бөөрөн шошийн 2 сортын 40 кг үрийн нөөцтэй болов. "Монгол орны газар тариалангийн төвийн бүсийн ургамал хамгааллын бодисын хэрэглээний мониторинг болон	100%

					үлдэгдлийн судалгаа, тэдгээрийг саармагжуулах, эрсдлийн үнэлгээ хийх технологи" 112 сая төслүүдийг Ургамал газар тариалангийн хүрээлэнг санхүүжүүлж судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлээд, үр дүнг хүлээн авах хугацаа болоогүй байна.	
4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.						
27	4.1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх төрөлжсөн анги, сургалтын тоог нэмэгдүүлэх, суралцах сонирхолтой, сургуулиа төгсөөд ажиллах боломжтой залуучуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах, мэргэшүүлэх;	2018 - 2022			Монгол ногоо төслийн хүрээнд 2020 онд 5 цэцэрлэг, 5 сургууль төслийн дэмжлэгт хамрагдаж хүлэмж, ус нөөцлөх сав, усалгааны системийн хамт, гар багаж, үр үрсэлгээний дэмжлэгийг үзүүллээ. Шинээр төсөлд хамрагдсан зорилтод бүлгийн үр шим хүртэгчдэд сургалт явуулж, хүнсний ногоо тарих, эко орчин бүрдүүлэхэд зориулж дэмжлэг үзүүлсэнээр хөдөө орон нутгийн сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн ногоо тарих, эко орчны талаар мэдлэг нэмэгдэж, үүнийг дагаад хүнсний ногооны хэрэглээ нэмэгдсэн.Төсөлд 14 сургууль, 17 цэцэрлэг нийт 9,280 м2 талбайд ногоо тарьж нийт 17 тонн ногоо хураан авч цэцэрлэгийн хүүхдийн хоол, багш ажилчдын хэрэгцээнд хэрэглэсэн байна. Налайх дүүргийн 123-р цэцэрлэгийн удирдлагаас багш ажилчид, эцэг эхчүүдтэй хамтран 1 га талбайд ногоо тарихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Тус талбайгаас цэцэрлэгийн багш, ажилчид 6.4 тонн ургац хураан авсан. 2020 онд цэцэрлэгүүдэд хэрэгжүүлсэн төслийн үр дүнг баримтжуулан “Эко цэцэрлэг” загварыг бусад цэцэрлэгүүдэд танилцуулан, цаашид түгээн дэлгэрүүлэх зорилгоор видео бичлэг болгон цахим сургалт, мэдээлэл бэлтгээд байна.	50%
28	4.2. Салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг гадаад орнуудын үр үйлдвэрлэх, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, олон	2018 - 2022			Салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг гадаад орнуудын үр үйлдвэрлэх, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, олон улсын үзэсгэлэнд оролцуулах ажил цар тахлын улмаас яваагүй боловч цахимаар БНСУ, ОХУ, БНХАУ, Японы улсын ногооны үр үржүүлэх хүрээлэнгүүдтэй Монгол ногоо төсөл, ХААИС-ийн Агроэкологийн сургууль, Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах төсөл, Тогтвортой Хөдөө аж ахуй төслүүдээр дамжуулан холбоо тогтоож 2021 оны тариалалтад шаардлагатай үр, технологийн талаархи мэдээлэл авч ногоочдод болон зах зээлд борлуулах үрийн импортын захиалга, гэрээгээ хийсэн. Хүнсний ногооны салбарт цахим сүлжээг нэвтрүүлэх шинэ технологийг Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг	90%

	улсын үзэсгэлэнд оролцуулах, сургаж дадлагажуулах замаар хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологи эзэмшүүлэх;				сайжруулах төсөл, НҮБ-ын ХХААБ-ын эрх зүйн орчин бүрдүүлэх хэсгийн хүрээнд "Пестицидийн хяналт, бүртгэлийн цахим систем нэвтрүүлэх", "Таримал ургамлын гарал үүслийн цахим системээр дамжуулан талбайн түүх хөтлөх систем нэвтрүүлэх", "Зах зээлийн цахим мэдээллийн систем " программыг ногоочдод сургах үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг эхлүүлсэн.Аймгуудын агрономчдыг 2020 онд хамруулсан ба 2021 онд сумын мэргэжилтэн, төслийн ажилтан нарт ашиглах, эзэмших, чадавхижуулах сургалтыг зохион байгуулна.	
29	4.3. Хүн амд дотоодын хүнсний ногоог зохистой хэрэглэхийн ач тусыг ойлгуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;	2018 - 2021			Монгол ногоо төслийн хүрээнд 2020 онд шинээр Төв аймгийн Сэргэлэн сум, Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт тус бүр нэг, нийт 5 гудамж сонгон 69 өрхийг ногоо тарьж сургах, гарын авлага технологиор хангаж ажиллалаа. 2020 оны байдлаар 22 жишиг гудамжны нийт 381 өрхтэй ажиллаж байна. Энэ онд шинээр жишиг гудамж төсөлд хамрагдсан 69 өрх нийт 4,731 м2 ил талбайд, 19 өрх 32 м2 хэмжээтэй хүлэмжинд 608 м2 талбайд нийт 5,339 м2 талбайд тариалалт хийсэн. Өмнөх жилүүдэд байгуулагдсан жишиг гудамжны зарим өрхүүд ногооны үрсэлгээгээ хамтран ургуулж гудамжны өрхүүдийн үрсэлгээг нийлүүлэхээс гадна, тухайн орон нутагтаа зарж борлуулан 3,2 сая төгрөгийн орлого олсон байна. 2020 онд жижиг гудамжны өрхүүд нийт 60 тонн ургац хураан авсан байна. Хураан авсан ургацынхаа 9 тонныг бусдад хандивлаж, 6 тонныг зарж борлуулсан бол 35 тонныг хүнсэндээ хэрэглэж нөөцөлсөн байна. Жишиг гудамжны өрхүүд 1 кг ногоог дунджаар 600 төгрөгөөр борлуулсан гэж тооцвол 20.5 сая төгрөгийн орлого олжээ.	100%
30	4.4. Хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, сурталчлах	2018 - 2021			Хүнсний ногооны хөрс боловруулалт, тарилт , арчилгаа, хураалт, хадгалалт боловсруулах талбайн сургалтыг Монгол ногоо төслийн хүрээнд Төв, Хэнтий, Ховд аймагт зохион байгуулж, 80 ногоочин хамрагдав.	90%

	ажиллагааг өргөжүүлэх;					
31	4.5. Хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэгчдийг харилцан туршлага судлуулах, гидропоник орчинд ургуулах арга, технологи нэвтрүүлэх, аймаг, орон нутагт үзүүлэх сургалт зохион байгуулах;	2018 - 2022			Хүлэмжийн аж ахуйн улсын үзүүлэх сургалтыг ХААИС-н Агроэкологийн сургуультай хамтран Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Ногоон хэрэмийн хүлэмжийн цогцолбор аж ахуй"- цогцолбор төвд 08 сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад 21 аймгийн агрономчид, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн ногооны секторын эрдэмтэд, ХААИС-ын Агроэкологийн сургуулийн багш нар, Өмнөговь аймгийн ногоочид, хоршоо, ТББ-н төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцов. Сургалтаар 1.5 га ил талбайд 12 төрлийн ургамлын үр үржүүлгийн болон товарын ургацын туршилт, зуны болон үрсэлгээний 15 хүлэмжид 7 төрлийн хүнсний ногооны үр үржүүлэг, говьд ургадаг мод, бутны үржүүлэг, говьд ургадаг эмийн ургамлын үржүүлэг, 5 хүлэмжинд 4 төрлийн хүнсний ногоо, 1 өвлийн хүлэмжид гоёл чимэглэлийн цэцэг, 1 өвлийн хүлэмжийг үрслэгийн үйлдвэр байдлаар тохижуулсаныг туршилга, санал солилцох, бусад аймагт нэвтрүүлж болох хэлэлцүүлэг хийв. Өмнөговь аймаг нь хүлэмжийн 5700 м.кв бүхий талбайгаас 7.2 тн хүнсний ногоо, ил талбайд таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан.	100%
32	4.6. Усалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн ашиглалт, таримлын ус хэрэглээ, технологийн талаар хүнсний ногоо тариалагчдад зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх;	2018 - 2022			Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн хүрээнд хамрагдсан бүлгүүдийн ногоочдод тухайн орон нутгийн хөрс, уур амьсгалын дата мэдээлэлүүдийг ашиглан тариалах хүнсний ногоо, жимс жимсгэнийхээ усалтын болон усалгааны норм, горимыг тооцох арга, тарималын усалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж улмаар усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийн менежментийн үйл ажиллагааг өөрөө удирдан зохион байгуулах арга барилыг эзэмшүүлэхэд зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу илтгэл, 21 хуудас гарын авлага материалыг боловсруулан бэлтгэж танхимын цахим сургалтыг 4-р сарын 20-22-ний өдрүүдэд, талбайн зөвлөгөө өгөх сургалтыг 2020 оны 07-р сарын 15-23-ний өдрүүдэд төслийн 4 суманд зохион явуулсан. БНХАУ-ын усалгааны тоног төхөөрөмжийн сургалт Цар тахалтай холбоотой гадаадаас ирэх мэргэжилтэн ирэх боломжгүй учир сургалт зохион байгуулаагүй 2021 онд хийхээр хойшилсон.	70%
33	4.7. Бага, дунд оврын техникийн ашиглалт,	2019 - 2022			ХААИС-ийн Инженерийн сургуультай хамтран хүнсний ногооны зориулалттай мотоблокийг ашиглах, шатахууны зарцуулалтыг тооцох аргачлалд зориулсан 2018 онд зохион байгуулсан сургалтаар гагасан зөвлөмжийг дахин хуулбарлаж	70%

	зориулалт, шатахуун зарцуулалт, бүтээлийн норм, технологийн сургалтыг танхимд болон талбайд зохион байгуулах;				мотоблок авсан ногоочдод хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан олгосон. Мөн Хөдөө аж ахуйг дэмжих сангаар борлуулсан бүх тоног төхөөрөмжийн ашиглалтын зааврыг монгол хэлээр нийлүүлэгчээр орчуулуулж ногоочдод олгох ажлыг зохион байгуулсан.	
34	4.8. Ногоочдыг сайн дураараа зохион байгуулалтад оруулж, ургацаа төв суурин газарт борлуулах ажлыг мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, арга зүйн сургалт, сурталчилгаа хийх;	2018 - 2022			Улсын хэмжээнд 828 аж ахуйн нэгж, хоршоо, 16.3 мянган өрх хүнсний ногооны тариалан эрхэлж байна. Хөтөлбөрийн дэмжлэгт 342 аж ахуйн нэгж, хоршоо, 9.2 мянган өрх хамрагдсан нь 2019 оныхоос 71 хоршоо, 1064 өрх илүү хамрагдлаа. Архангай, Баянхонгор, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, аймгуудад ААН, хоршоо нэмэгдсэн байна. “Хоршооны дундын хөрөнгө оруулалтын сангийн журам”-ыг боловсруулж төслийн хөрөнгө оруулалттайгаар Увс аймгийн Улаангом сум “Чандмань торгон үр” хоршоо, “Үрийн өгөөжит гол” хоршоо, “Комплекс хүлэмжит байц”, Сэлэнгэ аймгийн Ерөө сум “Ерөө Ургац” хоршоо, “Бороогийн шим” хоршоо, Дархан-уул аймгийн Орхон сум “Орхон шимт ногоон хөрс” хоршоо болон “Газар шим өгөөж” хоршоо, Төв аймгийн Борнуур сумын ногоочдын 39 бүлгийн 1048 өрх хоршоо болон нэгдсэн зохион байгуулалтад орж улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн. Хоршооны бүлэг тус бүр бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтанд хамрагдсан. Хоршоо тус бүр үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөгөө боловсруулахдаа агуулгын хувьд нэгдсэн нэг хөтөлбөрийн дагуу боловсруулсан. Үүнд: Хоршооны ерөнхий мэдээлэл, үйлдвэрлэлийн мэдээлэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, удирдлага зохион байгуулалт, зах зээлийн судалгаа, хүнсний ногооны үйлдвэрлэлийн төлөвлөгөө, хоршооны үйл ажиллагааны эдийн засгийн тооцоолол гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэсэн. Эдгээр хоршоо нь Улаанбаатар хотод ногооны борлуулалтыг хийхээр 6 цэгт газар, ТҮЦ-ний асуудлыг төслийн хүрээнд шийдсэн. Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоотой хамтран 7 бүлэг, хоршооны гишүүн 57 ногоочдыг үе шаттайгаар сургалтуудад хамруулж стандартын шаардлага хангасан өргөст хэмх, лууван, сармис, хүрэн манжин, төмс, 50ш хөрсний хучлага, 80 литр органик бордоо зэргээр дэмжлэг үзүүлэв. 2020 оны ургацын дүнгээр сармис 100 кг, шар манжин 58 тн, хүрэн манжин 30тн, ил талбайн өргөст хэмх 10.9 тн, шар лууван 15 тн, навал шүүсний лууван 9тн,	90%

				хүлэмжийн өргөст хэмх 600кг, төмс 4 тн-ыг тус хурааж нийт 59.4 сая төгрөг орлого бүрдүүлсэн.	
35	4.9. Дотооддоо үйлдвэрлэх шим болон биологийн бордоог хэрэглэх, хөрсний үржил шимийг сайжруулах, хашаажуулах технологийн сургалтыг бүсчлэн зохион байгуулах;	2019 - 2022		Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Экологожсон арга туршлага ашиглан хөрсний чийг, үржил шимийг нэмэгдүүлэх багц зөвлөх үйлчилгээний хүрээнд Хөрсний үржил шимийг сайжруулах, хашаажуулах, ойн зурвас байгуулах технологийн сургалт, талбайн өдөрлөгийг 2020 оны 08 дугаар сард Төв, Дархан-Уул аймагт бүсчлэн зохион байгуулж 200 гаруй ногоочид, тариаланчдыг хамруулсан.	100%
36	4.10. Хүнсний ногооны түгээмэл өвчин, хортон шавж, хог ургамлыг таних зорилго бүхий каталогийг хэвлүүлэн түгээх, хөнөөлт организмтай хүн, мал, амьтан, байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх технологийн сургалт, семинарыг зохион байгуулах;	2018 - 2022		2020 онд “Баруун бүсийн Баян-өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгуудын тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, судалгаа хийх, тэмцэх арга хэмээг боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй гэрээ байгуулсан. Тус хүрээлэнгээс дээрх аймгуудын тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалтын судалгааг хийж дуусган аймаг тус бүрийн судалгааны тайлан, хөнөөлт организмыг таних катологи, зөвлөмжийг ирүүлсэн. Судалгааны үеэр Ховд, Говь-Алтай аймгуудад тариалангийн талбайн зарим хэсэгт манай улсад гадаад хорио цээртэй хог ургамал, Увс, Завхан, Баян-Өлгий аймгуудын тариалангийн талбайн зарим хэсэгт дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт организм тархсаныг тогтоосон. ХХААХҮЯ-ны Газар тариалангийн чиглэлээр бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах ажлын хэсэг ажлыг хүлээн авч, тайлан болон зөвлөмж, хүнсний болон бусад таримлын талбайд тархсан хөнөөлт организмын катологи, хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг дээрх аймгуудад хүргүүлээд байна. Монгол-Германы Тогтвортой хөдөө аж ахуй төслийн багтай хамтран Завхан аймгийн Улиастай хотод 2020 оны 7 сарын 22-24-ний өдрүүдэд Ховд, Говь-Алтай, Завхан, Увс аймгуудын төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 60 гаруй тариаланчдад зориулан "Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйд зохистой дадал, ургамал хамгааллын цогц арга хэмжээг нэвтрүүлэх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний талаар Ургамал	100%

					хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд сургалт хийсэн ба тус яамнаас газар тариалангийн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүй, бодлогын талаар илтгэл тавьж оролцсон.	
37	4.11. Борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн-худалдааг бүх сум, дүүрэг, хороодод зохион байгуулж, орон нутагт туршлага солилцох, үзүүлэх сургалт хийх.	2018 - 2022			“Алтан намар-2020” үзэсгэлэн худалдаанд Мишээл экспо худалдааны төвд 15 аймгийн 31 сумын нийт 150 гаруй ногоочин, 3 аж ахуйн нэгж, 6 хоршоо, “Монгол ногоо”, “Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах”, “Адра” төсөл, ХААИС-ийн Агробиологийн их сургууль, ХААШУОУНТ, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, Хүлэмжийн холбоо, Ногоочдын холбоо зэрэг ТББ-д 40 гаруй нэр төрлийн чанар аюулгүй байдал хангасан гарал үүслийн бичигтэй 570 тн төмс, хүнсний ногоо, 8 нэрийн таримал болон байгалийн жимс, жимсгэнэ, 8 төрлийн гоёл чимэглэлийн мод бутны суулгац, 60 гаруй нэрийн эмийн ургамал, 20 нэрийн тасалгааны цэцэг зэрэг бүтээгдэхүүнээр оролцож нийт 350 гаруй сая төгрөгний борлуулалт хийсэн байна.. Мөн 21 аймаг 8-9 дүгээр саруудад аймгийн төвүүддээ "Ургацын баяр" нэгдсэн худалдаа, борлуулалтыг дэмжиж ажилласан байна. Архангай, Баян-өлгий, Баянхонгор, Булган, Говь-алтай, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өмнөговь, Дорнод, Дархан-уул, Увс, Ховд аймгууд санаачлага сайтай, хэрэглэгч олныг хамруулан ажилласан байна.	100%

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ